

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/эхний 7-р сарын байдлаар/

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 6.6 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 75 хувиар биелсэн байна.

Уулбаянаас бусад бүх сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 3.7-60.9 хувиар давж биеллээ.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 4.4 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 1.1 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 39.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны жилийн эцсээс 4.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 23.6 тэрбум төгрөг болсон нь 2011 оны жилийн эцсээс 6.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Газар тариалан: Тариалалтын эцсийн мэдээгээр 64.5 га-д төмс, 23.7 га-д хүнсний ногоо, 42.3 га-д тэжээлийн ургамал тариалсан нь урьд оны мөн үеэс төмс, хүнсний ногоо тариалалт доогуур, тэжээлийн ургамалын тариалалт дээгүүр байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 18 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 2.6 тэрбум төгрөгөөр дээгүүр, оны үнээр 67.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 3.3 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, ул боов, нүүрс, цайрын баяжмал, замын хавтангийн үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 7-р сард өмнөх 2011 оны жилийн эцсийнхээс 5.7 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана мах махан бүтээгдэхүүн 58.5 хувиар, жимс, жимсгэнэ 20.4 хувиар, хүнсний ногоо 19.3 хувиар өссөн байна.

Боловсролын үйлчилгээний үнэ, тариф жилийн эцэст байсан хэмжээндээ тогтвортой байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 7 сард 764 эх амаржиж, 773 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 406 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 56-аар олон байгаа бөгөөд вируст гепатит, цусан суулга, тэмбүү, трихоминиаз зэрэг өвчлөлүүд өссөн байна.


VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 893 болж, эхний 7 сард 121-ээр хасагдсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 70.7 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 20 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай дунд, 42.3 хувь нь бүрэн дунд, 7.2 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 7 сард 958 хүн шинээр бүртгүүлж, 805 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 488 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 7 сард 136 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 22 хүн нас барж, 41 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 150.3 сая төгрөгийн хохирол учирсны 148.5 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 108 хүн холбогдон сэжиглэгдсэний 27.8 хувь нь согтуугаар, 9.3 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 2040 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 507 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 83 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС